

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2025 оны эхний хагас жилийн биелэлт								
Д/д	Үйл ажиллагаа	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Санхүүжилт	Зорилтот түвшин 2025 он	Үндсэн эсэх	Хэрэгжилт
2. Олон нийтийн итгэлийг хүлээсэн авлигаас ангид нийтийн албыг бэхжүүлнэ.								
2.1. Төрийн албаны хүний нөөцийн удирдлага болон томилгооны ил тод, мэргэшсэн тогтвортой байдлыг бэхжүүлнэ.								
1	2.1.2. Төрийн албаны сул орон тооны талаарх мэдээллийг олон нийтэд ил тод мэдээлэх, сонгон шалгаруулах нэгдсэн цахим системийг хөгжүүлж, холбогдох эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.	2.1.2.2. Төрийн албаны сул орон тооны талаарх мэдээллийг олон нийтэд ил тод мэдээлэх, сонгон шалгаруулах нэгдсэн цахим системийн үйл ажиллагааг хэвшүүлэх	Нэгдсэн цахим системээр зохион байгуулагдсан сонгон шалгаруулалт	-	60 Улсын төсөв, бусад эх үүсвэр	100	Үгүй	Монгол Улсын Төрийн албаны зөвлөлөөс Шалгалтын цахим системийг шинэчилж, 4271 байгууллагыг хамарсан, нийт 228820 албан хаагчийн мэдээлэл бүхий “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо цахим систем” http://hh2.csc.lvg.mn/ -ийг 2025 оны 01 сараас хэрэглээнд нэвтрүүлсэн бөгөөд тус яамнаас ахлах түшмэлийн 7, дэс түшмэлийн 5 албан тушаалын сул орон тоог нөхөх шалгалтыг уг системийг ашиглан 2025 оны 04 дүгээр сарын 18-аас 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн хооронд бүртгэлийг хийж, тусгай шалгалтыг 2025 оны 05 дугаар сарын 06-ны өдөр зохион байгуулсан. Төрийн албаны зөвлөлийн Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны дэргэдэх Салбар зөвлөлөөс уг шалгалтын хүрээнд нийт 11 сул орон тоог нөхсөн талаарх тогтоолыг 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн 10/03 дугаартай албан бичгээр ирүүлсний дараа холбогдох албан хаагчдыг томилох тушаалуудыг гаргаад байна.
2.3. Нийтийн албан тушаалтан зарлагаа мэдүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлж, татварын болон төрийн бусад мэдээлэлтэй уялдуулан хяналт тавих цахим системийг хөгжүүлнэ.								
2	2.3.2. Мэдүүлгийн бүрдүүлэлт, хяналт шалгалтын үйл ажиллагаанд төрийн байгууллагын мэдээллийг бүрэн ашиглаж, эрсдэлд суурилсан цахим систем хөгжүүлнэ.	2.3.2.1. Мэдүүлгийн бүрдүүлэлт, хяналт шалгалтын үйл ажиллагааны эрсдэлд суурилсан цахим систем хөгжүүлэх	Цахим системээр зохион байгуулагдсан мэдүүлгийн бүрдүүлэлт, хяналт шалгалтын үйл ажиллагаа	-		100	Үгүй	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Ухаалаг засаг 2 төслийн хүрээнд “Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтийн систем болон тоног төхөөрөмж” төслийн гүйцэтгэгчээр Ай ти зон ХХК ажиллаж байгаа ба Мэдүүлэг бүрдүүлэлт, хяналт шалгалтын программ цогц хангамжийг хөгжүүлж, өгөгдлийн сан болон техник хангамжийн бүрэн шинэчлэлт хийгдэж байна.
2.5. Төрийн үйл ажиллагааны мэдээллийг цахимжуулах замаар иргэдийн мэдэх эрхийг баталгаатай эдлүүлнэ.								
3	2.5.1. Төрийн цахим үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.	2.5.1.1. Төрөөс хүн, хуулийн этгээдэд цахим хэлбэрээр үзүүлэх үйлчилгээний тоог нэмэгдүүлэх	Цахимаар үзүүлж буй төрийн үйлчилгээ	897	786 Улсын төсөв, бусад эх үүсвэр	1070	Тийм	Монгол Улсын Засгийн газар олон улсын сайн туршлагад үндэслэн, иргэдийнхээ ахуйн онцлогт тааруулан, цахим шилжилтийг үе шаттай хэрэгжүүлж, төрийн байгууллага хоорондоо, төрийн байгууллага бизнесийн байгууллагатай, төрийн байгууллага иргэнтэй өгөгдөл, мэдээлэл солилцох үндсэн үүрэгтэй нийтийн мэдээллийн дэд бүтцийг тасралтгүй хөгжүүлж, төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэн, иргэд төрийн үйлчилгээг чирэгдэлгүй, хүнд сурталгүй, нэг сувгаар хүлээн авах, төрийн шийдвэр гаргалтад өөрийн дуу хоолойг хүргэх, санал хүсэлтээ уламжлах боломжтой болсон. Тодруулбал: Монгол Улсын Засгийн газар 2017 онд төрийн байгууллага хоорондын өгөгдөл солилцоог сайжруулах, төрийн цахим үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор төрийн мэдээлэл солилцооны систем “ХУР”, иргэнийг цахим орчинд таньж баталгаажуулах “ДАН” системийг хөгжүүлж, хэрэглээнд нэвтрүүлсэн нь одоогийн үндсэн болон дэмжих системүүдийн суурийг тавьсан үйл явдал байв. Түүнчлэн хамгийн их цаг зарцуулдаг, хүнд сурталтай хэмээн олон жил иргэд шүүмжилж ирсэн төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, төрийн үйлчилгээний нэгдсэн систем “E-Mongolia”-г 2020 оны 10 дугаар сард ашиглалтад оруулж, 2020 онд төрийн 23 байгууллагын 181 үйлчилгээ, 2021 онд 59 байгууллагын 606 үйлчилгээ, 2022 онд 69 байгууллагын 897 үйлчилгээ, 2023 онд 86 байгууллагын 1033 үйлчилгээг, 2024 онд 86 байгууллагын 1,250 үйлчилгээг, 2025 оны эхний хагас жилийн байдлаар төрийн 87 байгууллагын 1263 үйлчилгээг, бүртгэлтэй 2,020,951 хэрэглэгчид 80,419,184 удаа (амжилттай 77,194,768) дамжуулж, 2020 оноос хойших хугацаанд нийт 1.55 тэрбум төгрөгийн шууд бус хэмнэлт (цаас, цаг хугацаа, унааны зардал)-ийг бий болгосон байна.

4	2.5.2. Олон нийтэд нээлттэй, ил тод болгохоор заасан мэдээллийг тухай бүр цахим системд нээлттэй байршуулж, хуулийн хэрэгжилтэд хоёр жил тутам үнэлгээ хийж олон нийтэд ил тод мэдээлнэ.	2.5.2.1. Олон нийтэд нээлттэй, ил тод болгохоор заасан мэдээллийг тухай бүр цахим системд нээлттэй байршуулах	Олон нийтэд нээлттэй байршуулсан мэдээлэл	3		100	Үгүй	Нээлттэй мэдээллийн систем (shilen.gov.mn)-ийн 2.0 хувилбар дахь “Шилэн индекс”-ийн үнэлгээ, харьяа болон салбар байгууллагуудын хэмжээнд “Шилэн индекс”-ийн тайланг хүлээн авч, хянах, үнэлэх, баталгаажуулах нээлттэй мэдээллийн дата оруулах, шинэчлэх, байгууллага бүртгэх, системд хандах эрх нээх зэрэг асуудлаар мэдээлэл хариуцагч байгууллагын нийт 200 гаруй албан хаагчдад зөвлөгөө, мэдээллийг хүргэж ажилласан. Тус яам 2025 оны 1 дүгээр улирлын “Шилэн Индекс”-ийн тайланг илгээж 97,96% үнэлэгдсэн байна. Мөн салбар байгууллагуудын ирүүлсэн тайлангийн үнэлгээ хувь: Харилцаа холбооны зохицуулах хороо 98%, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар 96%, Мэдээлэл холбооны сүлжээ ХХК 95%, Үндэсний дата төв 89% И-Монгол академи УТҮГ 89%-тай тус тус үнэлэгдсэн. Түүнчлэн Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн А/88 дугаар тушаалаар “Нээлттэй мэдээллийн shilen.gov.mn системийн 3.0 хувилбарыг нэвтрүүлэх” ЦХИХХЯ/20250103046 дугаартай төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах Үнэлгээний хороо байгуулагдан ажиллаж байна.
5	2.5.3. Төрийн байгууллагын зөвшөөрөл олгох үйл ажиллагааг үе шаттайгаар бүрэн цахимжуулна.	2.5.3.1. Төрийн байгууллагын зөвшөөрөл олгох үйл ажиллагааг үе шаттайгаар бүрэн цахимжуулах	Цахимаар олгож буй зөвшөөрөл	66	150 Улсын төсөв, бусад эх үүсвэр	100	Тийм	Монгол Улсын Их Хурлаас 2022 онд Зөвшөөрлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг батлан, 251 төрлийн “тусгай зөвшөөрөл”, 130 төрлийн “энгийн зөвшөөрөл”, нийт 381 төрлийн зөвшөөрлийг олгохоор хуульчилсан ба 2024 онд нийт 251 тусгай зөвшөөрлөөс 178 төрлийн тусгай зөвшөөрлийг цахим хэлбэрт шилжүүлж, Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн системийн дэд суваг болох e-business.mn-д нэгтгэсэн. Зөвшөөрөл олгох үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлснээр 2025 оны 03 дугаар сарын байдлаар “license.mn”-ээр 76, “e-business.mn”-ээр 43, эрх бүхий байгууллага өөрийн системээр 116, уламжлалт буюу цаасан хэлбэрээр 16 тусгай зөвшөөрлийг олгож, зөвшөөрлийн нэгдсэн санд 151746 нэгж зөвшөөрлийн мэдээлэл бүртгэгдсэн байна. Үлдсэн 73 тусгай зөвшөөрлийг хүн, хуулийн этгээд уламжлалт аргаар буюу биеэр очиж, цаасаар харилцах байдлаар олгосон хэвээр байна.
2.6. Салбарын эрсдэлийг оновчтой тодорхойлж, түүнд чиглэсэн арга хэмжээг үе шаттайгаар, цогц байдлаар хэрэгжүүлнэ.								
6	2.6.2. Эрсдэлд суурилсан авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлж хэвшүүлнэ.	2.6.2.1. Шударга байдлын үнэлгээгээр хамгийн бага оноо авсан яам, агентлаг, нутгийн захиргааны байгууллагад авлигын эрсдэлийг бууруулах тусгайлсан төлөвлөгөө хэрэгжүүлэх	Тухайн яам, агентлаг, нутгийн захиргааны байгууллагын Шударга байдлын үнэлгээний онооны өсөлт	-	20 Улсын төсөв, бусад эх үүсвэр	10	Тийм	Авлигатай тэмцэх газраас төрийн байгууллагуудын 2024 оны Шударга байдлын үнэлгээний судалгааг Бодлогын шийдэл ТББ-аар гүйцэтгүүлсэн бөгөөд тус байгууллагатай хамтран ажиллаж холбогдох албан хаагч, байгууллага, иргэдийг судалгаанд хамрагдахад дэмжлэг үзүүлж ажилласан.
3. Авлигатай тэмцэх үйл ажиллагаанд иргэн, иргэний нийгмийн байгууллага, хэвлэл мэдээллийн бодит оролцоо, үр дүнтэй хяналтыг бэхжүүлнэ.								
3.2. Төрийн бодлого боловсруулах, шийдвэр гаргах, хэрэгжүүлэх болон хэрэгжилтийг үнэлэхэд иргэн, иргэний нийгмийн байгууллагын бодит оролцоог хангаж иргэнд ээлтэй бодлого, шийдвэр гаргах нөхцөлийг хэвшүүлнэ.								
7	3.2.3. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль, Нийтийн сонсголын тухай хуульд заасан сонсголыг зохион байгуулахдаа иргэн, иргэний нийгмийн байгууллагын оролцоог нэмэгдүүлнэ.	3.2.3.2. Нийтийн сонсголын тухай хуульд заасан сонсголд иргэн, иргэний нийгмийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх	Сонсголд оролцсон ажиглагч, оролцогчдын тооны өсөлт	5	40 Улсын төсөв, бусад эх үүсвэр	100	Үгүй	Тус яамнаас Нийтийн сонсголын тухай хуульд заасан сонсгол зохион байгуулаагүй болно.

8	3.2.4. Нийтийн мэдээллийг нээлттэй өгөгдлийн стандартын дагуу ил болгож, иргэн шууд хяналт тавих боломжийг бүрдүүлнэ.	3.2.4.4. Нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг зохион байгуулах, үнэлгээ хийх, зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийн үйл ажиллагааг өргөжүүлэх	Нэмэлт, өөрчлөлт оруулсан хууль тогтоомж	1		1	Үгүй	Хууль зүй, дотоод хэргийн сайд, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн А/268, А/48 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг зохион байгуулах, үнэлгээ хийх, зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий зөвлөлийн ажиллах журам”-ын 2.2-т заасны дагуу “Зөвлөлийн үйл ажиллагааны 2025 оны эхний хагас жилийн төлөвлөгөө”, “Үнэлгээний хуваарь”-ийг батлуулсан. Тус зөвлөлийн нарийн бичгийн чиг үүргийг Хууль зүй, дотоод хэргийн яамнаас хэрэгжүүлж байна.
3.3. Төрийн үйл ажиллагаанд хараат бус хөндлөнгийн хяналт тавих иргэний нийгмийн байгууллагыг бэхжүүлэхэд шаардлагатай дэмжлэг бий болгоно.								
9	3.3.1. Иргэний нийгмийн байгууллагын эрх зүйн орчныг шинэчлэхдээ баримт, судалгаа, зөвлөмжийг үндэслэн тэдгээрийн бодит оролцоог хангана.	3.3.1.1. Иргэний нийгмийн байгууллагын эрх зүйн орчныг шинэчлэх хуулийн ажлын хэсэгт ажиллах иргэний нийгмийн байгууллагын төлөөллийн тоог нэмэгдүүлэх	Хуулийн ажлын хэсгийн нийт гишүүдийн тоонд эзлэх иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл	-		10	Үгүй	Иргэний нийгмийн байгууллагын эрх зүйн орчныг шинэчлэх хуулийн ажлын хэсэгт ажиллах иргэний нийгмийн байгууллагын төлөөллийн тоог нэмэгдүүлэх арга хэмжээ нь тус яамны эрхлэх асуудал, чиг үүрэгт шууд хамааралгүй болно.
10		3.3.1.4. Авлигатай тэмцэх зорилго бүхий иргэний нийгмийн байгууллагын сүлжээ, иргэдийн сайн дурын хөдөлгөөнийг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилт	-	400 Улсын төсөв, бусад эх үүсвэр	30	Үгүй	Авлигатай тэмцэх зорилго бүхий иргэний нийгмийн байгууллагын сүлжээ, иргэдийн сайн дурын хөдөлгөөнийг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээ тус байгууллагын чиг үүрэгт шууд хамааралгүй болно.
11		3.3.1.5. “Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ыг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагад дэмжлэг үзүүлэх, олон нийтийн хяналт хэрэгжүүлэх этгээдийг чадавхжуулах	Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд хэрэгжүүлсэн Олон нийтийн хяналтын үйл ажиллагаа	-	210 Улсын төсөв, бусад эх үүсвэр	44	Үгүй	Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 109 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ыг мөрдөж ажиллахыг төрийн бүх шатны байгууллагын дарга нарт даалгасны дагуу журмын хэрэгжилтийг хангах хүрээнд уг ажлыг хөндлөнгийн хараат бус этгээдээр гүйцэтгүүлэхээр тус яамны 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж, холбогдох гэрээг “Судлаач соно бодлого судалгааны төв” НҮТББ-тай байгуулан ажилласан. Үйлчилгээ үзүүлэгч нь журмын 2.1-т заасан чиглэл, үйл ажиллагааны дагуу Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам болон түүний харьяа байгууллагууд болох Үндэсний дата төв УТУГ, Радио, телевизийн үндэсний сүлжээ УТУГ, И-Монгол академи УТУГ, Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв УТУГ, Кибер аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албан дээр 2024 оны 10 дугаар сарын 21-ний өдрөөс 2024 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн хооронд ажиллаж, холбогдох дүгнэлт, зөвлөмжийг гарган хүлээлгэн өгсөн болно. Тайлант онд тус яамнаас хэрэгжүүлэх авлигын эсрэг төлөвлөгөөнд уг дүгнэлт, зөвлөмжийн дагуу хэрэгжүүлэх арга хэмжээг тусган тус яамны мэдээ, мэдээллийн ил тод байдлыг хангахаар ажиллаж байна.
4. Хувийн хэвшилд авлигыг үл тэвчих соёлыг төлөвшүүлнэ.								
4.2. Шударга өрсөлдөөнийг дэмжих, бизнесийн үйл ажиллагаанд нөлөөлж байгаа авлигын хүчин зүйлсийг арилгана.								
12	4.2.2. Бизнесийн үйл ажиллагаа, шударга өрсөлдөөнд сөргөөр нөлөөлж байгаа хүчин зүйлсийг тодорхойлох суурь судалгааг үе шаттайгаар зохион байгуулж, хариу арга хэмжээг хэрэгжүүлнэ.	4.2.2.1. Бизнесийн үйл ажиллагаа, шударга өрсөлдөөнд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлийг тодорхойлох суурь судалгааг чиглэл бүрээр, үе шаттайгаар зохион байгуулах	Зохион байгуулсан судалгаа	-	100 Улсын төсөв, бусад эх үүсвэр	1	Үгүй	Тус байгууллагын эрхлэх асуудалд хамааралгүй болно.
13		4.2.2.2. Бизнесийн үйл ажиллагаа, шударга өрсөлдөөнд сөргөөр нөлөөлж байгаа хүчин зүйлсийг бууруулах хөтөлбөр хэрэгжүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилт	-	350 Улсын төсөв, бусад эх үүсвэр	10	Үгүй	Тус байгууллагын эрхлэх асуудалд хамааралгүй болно.

14	4.2.4. Дотоодын болон гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжихэд олон улсын байгууллагаас шаардах Комплаенсын шаардлагыг хангана.	4.2.4.8. Дотоодын болон гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжихэд олон улсын байгууллагаас шаардах Комплаенсын шаардлагыг хангах зорилгоор төрийн өмчит хуулийн этгээдэд ISO 37001 Авлигын эсрэг менежментийн тогтолцоог нэвтрүүлэх	Стандарт нэвтрүүлсэн болон нэвтрүүлэхээр ажиллаж байгаа хуулийн этгээд	-	200 Улсын төсөв, бусад эх үүсвэр	5	Үгүй	Тус байгууллагын эрхлэх асуудалд хамааралгүй болно.
6. Авлигын гэмт хэргийн шинжийг хийдэлгүй тодорхойлох, хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотой эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.								
6.4. Шаардлагатай бусад хууль тогтоомжийг боловсронгуй болгоно.								
15	6.4.11. Төрийн бүх шатны байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн авлигатай тэмцэх төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааг сайжруулна.	6.4.11.1. Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг бүрэн хангах	Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт	70.1	300	100	Тийм	Тус яамнаас 4 зорилтын хүрээнд 9 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.
7. Төсөв, санхүү, аудитын хяналтыг сайжруулан, худалдан авах ажиллагааны авлигын эрсдэлийг бууруулна.								
7.3. Засгийн газрын өр, тусгай сан, гадаадын зээл, тусламжийн ил тод байдлыг нэмэгдүүлэх, менежментийг сайжруулах чиглэлээр хууль тогтоомжийг боловсронгуй болгоно.								
16	7.3.3. Тусгай сангуудын үйл ажиллагааг олон улсын сангийн удирдлагын жишигт нийцүүлж шилэн болгох, эрсдэлийн үнэлгээг тодорхой хугацаанд давтамжтай хийж, аудитын үр дүнгээр нийтийн сонсгол зохион байгуулна.	7.3.3.1. Тусгай сангуудын үйл ажиллагааг олон улсын сангийн удирдлагын жишигт нийцүүлж шилэн болгох арга хэмжээ авах	Арга хэмжээ	-		2	Үгүй	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын багцад хамаарах Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сан болон Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан нь холбогдох хууль, журмын хүрээнд тухай бүр төсөл арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж тус бүрийн Хяналтын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, санал авч Сангийн дарга буюу ЦХИХХ-ны сайдаар батлуулан яамны худалдан авах ажилгааны төлөвлөгөөнд тусгуулан нэгдсэн төлөвлөгөөг https://user.tender.gov.mn -д олон нийтэд нээлттэй байдлаар байршуулаад байна. Төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд нээлттэйгээр нийтэлж, тендер шалгаруулалтыг зохион байгуулдаг бөгөөд тендерт шалгарч гэрээ байгуулсан оролцогчдын мэдээллийг Худалдан авах ажиллагааны цахим системд олон нийтэд нээлттэйгээр мэдээллийг байршуулж, санхүүжилт олгосон мэдээллийг шилэн дансны цахим системд тухай бүр байршуулан ажиллаж байна.
9. Соён гэгээрүүлэх үйл ажиллагааг олон нийтийн оролцоонд тулгуурлан цогц байдлаар зохион байгуулна.								
9.2. Олон нийтийг авлигаас ангид байлгах, нийгмийн ёс суртахууныг дээшлүүлэх зорилгоор үндэсний контентыг бүтээж, түгээнэ.								
17	9.2.2. Авлигыг үл тэвчих үзлийг түгээн дэлгэрүүлэхэд соёл, урлаг, спорт, хэвлэл мэдээллийн оролцоог нэмэгдүүлж, мэдээлэл солилцох сувгийг хөгжүүлнэ.	9.2.2.1. Авлигыг үл тэвчих үзлийг түгээн дэлгэрүүлэхэд соёл, урлаг, спорт, хэвлэл мэдээллийн оролцоог нэмэгдүүлж, мэдээлэл солилцох сувгийг хөгжүүлэх	Авлигыг үл тэвчих үзлийг түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагаанд оролцсон соёл, урлаг, спорт, хэвлэл мэдээллийн салбарт хамаарах хуулийн этгээд, хувь хүн	18	300 Улсын төсөв, бусад эх үүсвэр	28	Үгүй	Тус яамны үндсэн чиг үүрэгт хамаарахгүй байна. Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сангаас үйлдвэрлэхэд өртөг өндөр үндэсний бүтээлийг дэмжихээр нээлттэй тендерийг зарлаад байна.
9.4. Хүүхдийн шударга байдалд сөргөөр нөлөөлж байгаа хүчин зүйлсийг бууруулах арга замаар ёс зүйн төлөвшлийг дэмжинэ.								

18	9.4.1. Хүүхдийн шударга байдлыг төлөвшүүлэх ёс зүй, ёс суртахууны зөв төлөвшил олгоход чиглэсэн сургалт, нөлөөллийн хөтөлбөрийг насны ангилал, орчин үеийн чиг хандлагад нийцсэн байдлаар судалгаанд тулгуурлан боловсруулна.	9.4.1.1. Хүүхдийн шударга байдлыг төлөвшүүлэхэд чиглэсэн сургалт, нөлөөллийн хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилт	-	250 Улсын төсөв, бусад эх үүсвэр	10	Үгүй	Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг "Girls in ICT" өдөрт зориулсан арга хэмжээ 2025.04.30-ны өдөр амжилттай зохион байгуулагдаж, энэхүү арга хэмжээг НҮБ-ын Хүүхдийн Сан, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, "И-Монгол академи" УТҮГ, Харилцаа холбооны зохицуулах хороо, Монголын хүүхдийн зөвлөлтэй хамтран зохион байгуулсан бөгөөд ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн 150 гаруй охид оролцсон юм. Тус арга хэмжээгээр хүүхэд цахим орчинд худал үнэн мэдээллийг таниж мэдэх, цахим орчинд өөрийн аюулгүй байдлаа хэрхэн хамгаалах, цахим орчинд шударга байдлыг төлөвшүүлэх мэдээллийг хүргэх нөлөөллийн арга хэмжээ юм.
9.5. Төрийн албанд ёс зүйн шаардлагыг хангасан иргэнийг сонгон шалгаруулж ажилд авах соёлыг төлөвшүүлж, тогтолцоог бүрдүүлнэ.								
19	9.5.2. Шүгэл үлээхийг дэмжих зорилгоор мэдээлэл өгөх суваг, хамгаалалтын арга хэлбэр, ач холбогдлын талаар олон нийтэд сурталчилна.	9.5.2.1. Шүгэл үлээхийг дэмжих зорилгоор мэдээлэл өгөх суваг, хамгаалалтын арга хэлбэр, ач холбогдлын талаар олон нийтэд сурталчлах	Зохион байгуулсан арга хэмжээ	-	150 Улсын төсөв, бусад эх үүсвэр	10	Үгүй	Тус яамнаас авлига, ашиг сонирхлын зөрчлийг мэдэгдэх 110 утсыг олон нийтэд сурталчлан таниулах чиглэлээр дараах ажлыг хийж гүйцэтгэхээр сайдын ажлын албанаас төлөвлөөд байна: 1.УИХ-ын гишүүн, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүүгийн ажлын тайлан сонинд 110 утасны дугаартай холбоотой мэдээлэл, постер хэлбэрээр байршуулна. 2.Өргөн нэвтрүүлгийн сангаас зарласан 6 тендэртэй холбоотой АТГ-аас ирсэн зөвлөмжийн хүрээнд REEL хийх, болон 110 утасны талаарх мэдээллийг оруулна. 3.Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам дээр 110 дугаартай холбоотой постер оруулна. 4.УИХ-ын гишүүн Ц.Баатархүүгийн ажлын пэйж хуудас дээр 110 дугаартай холбоотой постер оруулна.
10. Гамшгаас хамгаалах, онц байдлын үеийн үйл ажиллагаа болон үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлан чиг үүрэг бүхий байгууллагын үйл ажиллагаанд авлигаас урьдчилан сэргийлэх тогтолцоо бүрдүүлнэ.								
10.2. Гамшгаас хамгаалах болон онц байдлын үеийн хариу арга хэмжээний санхүүжилт, хандив, тусламжийн үйл ажиллагаанд авлигаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох бодлогын баримт бичгийг боловсруулж, гүйцэтгэлийн								
20	10.2.3. Гамшгаас хамгаалах болон онц байдлын үеийн хандив, тусламжийг бүртгэх, зарцуулалтыг ил тод болгох, хяналт тавих олон нийтэд нээлттэй цахим системийг нэвтрүүлнэ.	10.2.3.1. Гамшгаас хамгаалах болон онц байдлын үеийн хандив, тусламжийг бүртгэх, зарцуулалтыг ил тод болгох, хяналт тавих олон нийтэд нээлттэй цахим систем нэвтрүүлэх, цахим системийг боловсронгуй болгох	Цахим системийг үүсгэсэн, сайжруулалт	-	600 Улсын төсөв, бусад эх үүсвэр	1	Үгүй	Уг асуудал нь тус яамны эрхлэх асуудлын хүрээнд хамааралгүй бөгөөд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 29.1-т мэдээлэл хариуцагч нь нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө нийтийн мэдээллийн систем хоорондын харилцан уялдаа, нийтийн мэдээллийн системийн эдийн засгийн үр ашигтай байдал, хэрэглэх технологийн нийцэл, хүний хэрэглээнд тохирсон байдал, аюулгүй, найдвартай байдлын шийдэл, аюулгүй, найдвартай байдлын шийдэл болон бусад шаардлагатай асуудлаар цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар зөвлөмж, дүгнэлт гаргуулахаар заасан. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн А/55 дугаар тушаалаар дээрх зөвлөмж, дүгнэлтийг гаргах байнгын ажиллагаатай Ажлын хэсгийг 9 хүний бүрэлдэхүүнтэй байгуулаад байна. Одоогоор тус системийг хөгжүүлэх талаар хуульд заасан зөвлөмж, дүгнэлт гаргуулах хүсэлт ирээгүй байна.
10.3. Ирээдүйд тулгарч болзошгүй нөхцөл байдлын үеийн авлигын эрсдэлийг тооцоолон хариу арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, учирч болох хор хохирлоос урьдчилан сэргийлнэ.								
21	10.3.3. Шинжлэх ухаан, технологи, инновацыг нэвтрүүлэх байдлаар авлигын эрсдэлийг тодорхойлдог болно.	10.3.3.1. Шинжлэх ухаан, технологи, инновацыг нэвтрүүлэх байдлаар авлигын эрсдэлийг тодорхойлох	Шинжлэх ухааны шинэ арга, аргачлал, технологи, инноваци ашигласан авлигын эрсдэлийн үнэлгээ	-	340 Улсын төсөв, бусад эх үүсвэр	1	Үгүй	Тус ажлын үндсэн хэрэгжүүлэгч Авлигатай тэмцэх газраас хамтран ажиллах талаар чиглэл өгөөгүй байна.